



БАТЛАВ.  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ц.ЧОГСОМЖАВ

2022 оны 09 дугаар сарын 09

УДИРДАМЖ

2022 оны 09 дугаар сарын 07

Чингис хот

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙХ ТУХАЙ**

**Зорилго:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн дагуу хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөн туслах

**Хугацаа:** 2022 оны 09 дугаар сарын 19-нөөс 2022 оны 09 дугаар сарын 22-ны өдрүүдэд багтаан явуулна.

**Ажиллах хэсгийн бүрэлдэхүүн:**

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Ганчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Уянга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Г.Пүрэвбаатар	Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Г.Ариунхүү	Төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн
	С.Лхагвацэрэн	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

**Хамрах хүрээ:** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Орон нутгийн өмчийн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Статистикийн хэлтэс

**Хяналт-шинжилгээнд хамрагдах асуудлын чиглэл:**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийг хяналтад авсан байдал

2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт

3. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

4. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдал

5. Төрийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт

6. Салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний төлөвлөлт, хэрэгжилт

7. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт

8. Байгууллагын дарга болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо

9. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын хэрэгжилт

Жич: Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж дүгнэнэ.

Ажлын хэсгийг ажиллах үед хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах асуудлаа бүрэн хамруулж хариуцсан албан хаагчаа бэлэн байлгаж оролцуулахыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**